

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.36 дахь заалт:**

3.1.36. "ус дахин ашиглах" гэж хаягдал усыг дахин ашиглах цэвэрлэсэн усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, зориулалтын дагуу ашиглахыг;

**2/9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт:**

9.1.6. хаягдал ус цэвэрлэх, дахин ашиглах үйлдвэрийг байгуулах, өргөтгөх, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг татварын бодлогын дэмжлэг, зээлийн хүүгийн татаас, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг дэмжинэ;

**3/22 дугаар зүйлийн 22.19 дэх заалт:**

22.19. дулааны цахилгаан станц болон хүнсний бус үйлдвэрлэл, техникийн хэрэгцээнд гүний ус ашиглахыг хязгаарлаж, дахин ашиглах цэвэрлэсэн усыг ашиглуулах бодлого баримтална.

**4/28 дугаар зүйлийн 28.20, 28.21 дахь хэсэг:**

28.20. Энэ хуулийн 28.4-т заасан ус ашиглах дүгнэлт гаргахдаа тухайн ус хэрэглээний зориулалтад дахин ашиглах цэвэрлэсэн ус ашиглах боломжийг эн тэргүүнд авч үзнэ.

28.21. Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 28.6, 28.11-д заасан ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг, гэрээ байгуулахгүйгээр дахин ашиглах цэвэрлэсэн усыг ашиглаж болно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг:**

15.9. Хаягдал ус цэвэрлэх, дахин ашиглах үйлдвэрийг байгуулах, өргөтгөх, шинэ технологи нэвтрүүлэхэд зориулан гаргасан хөрөнгө оруулалтын зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцно.

**2/22 дугаар зүйлийн 22.5.23 дахь заалт:**

22.5.23. дахин ашиглах цэвэрлэсэн ус үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувь хөнгөлнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ**

**ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.1.6 дахь хэсэг:**

5.1.6.дахин ашиглах цэвэрлэсэн усыг эрчим хүчний салбарт ашиглахтай холбоотой техник, технологийн шинэчлэл хийхэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх.

**2/9 дүгээр зүйлийн 9.1.25, 9.1.26 дахь заалт:**

9.1.25.цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ус ашиглалт, дахин ашиглах цэвэрлэсэн ус ашиглалтын хэрэгжилтэд холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран хяналт тавих.

9.1.26.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.16-т заасан гэрээг бүртгэх.

**3/14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалт:**

14.2.4.дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс дулааны шугамаас унд, ахуйн зориулалтаар ус ашиглуулахгүй байх үүрэгтэй.

**4/25 дугаар зүйлийн 25.1.13 дахь заалт:**

25.1.13.цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа дахин ашиглах цэвэрлэсэн ус ашиглах боломжийг тэргүүнд авч үзнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ

## ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 3.23, 3.24, 3.25, 3.26 дахь заалт нэмсүгэй:

3.23.дахин ашиглах цэвэрлэсэн ус үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хороо
3.24. дахин ашиглах цэвэрлэсэн ус үйлдвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хороо
3.25. дахин ашиглах цэвэрлэсэн ус дамжуулах, түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хороо
3.26. дахин ашиглах цэвэрлэсэн усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хороо

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн "засвар үйлчилгээнд" гэсний дараа "болон хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ**

**ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтын "цэвэр," гэсний дараа " дахин ашиглах цэвэрлэсэн," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол улсын нийслэл улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.16 дахь заалтын "цэвэр" гэсний дараа ", дахин ашиглах цэвэрлэсэн," гэж, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын "цэвэр," гэсний дараа "дахин ашиглах цэвэрлэсэн," гэж, мөн зүйлийн 17.2.2 дахь заалтын "цэвэр" гэсний дараа ", дахин ашиглах цэвэрлэсэн" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын "цэвэр," гэсний дараа "дахин ашиглах цэвэрлэсэн," гэж, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын "цэвэр," гэсний дараа " дахин ашиглах цэвэрлэсэн," гэж, мөн зүйлийн 4.1.28 заалтын "цэвэр," гэсний дараа " дахин ашиглах цэвэрлэсэн," гэж, мөн зүйлийн 4.1.35 дахь заалтын "байгууламж," гэсний дараа "дахин ашиглах цэвэрлэсэн усны шугам сүлжээ," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---